



Mongol Bank



МОНГОЛБАНК

ИНФЛЯЦЫН ТАЙЛАН

2023

6-Р САР*

* Энэ удаагийн төсөөлөл, бодлогын шинжилгээнд 2023 оны 6-р сард батлагдсан төсвийн тодотголын нөлөөг тусгаагүй болно.

АГУУЛГА

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ.....	3
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР	4
ТОЙМ.....	5
1. ИНФЛЯЦ	7
1.1. Инфляцын цаашдын төлөв	7
1.2. Инфляцын гүйцэтгэл.....	9
1.3. Төсөөллийн зөрүү.....	10
2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ	10
2.1. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв	10
2.2. Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл	13
3. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН	16
3.1. Хөдөлмөрийн зах зээл.....	16
3.2. Мөнгө, санхүүгийн зах зээл	18
3.2.1. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд.....	18
3.2.2. Хүү.....	20
3.2.3. Валютын ханш.....	21
3.2.4. Хөрөнгийн зах зээл	22
3.3. Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр.....	25
4. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН	27
4.1 Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл	27
4.2. Экспортын үнийн төлөв.....	28
4.3. Төлбөрийн тэнцэл	29

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ

Төв банкны тухай хуульд **Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах** гэж тодорхойлсон байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк **инфляцыг 2023-2024 онд жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахыг** зорьж байна.

Монголбанкнаас мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, мөнгө, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцын түвшин, түүний хүлээлтийг тогтворжуулахыг зорьдог. Түүнчлэн, 2018 оноос эхлэн макро зохистой бодлогын хүрээнд системийн хэмжээнд мөрдүүлэхүйц банкны зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, үүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсвэл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдах зэрэгт чиглэсэн арга хэмжээг мөнгөний бодлогын арга хэрэгслүүдтэй хослуулан хэрэглэх стратегийг баримталж байна.

Монголбанк мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй харилцах харилцааны нээлттэй байдалд ач холбогдол өгч байна. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гадаад эдийн засаг, санхүүгийн салбар, нийт эрэлт, нийлүүлэлт, ажил эрхлэлт, үнэ, өртгийн хүчин зүйлс зэргийг Инфляцын тайланд танилцуулж, улирал тутам олон нийтэд мэдээлж байна. Төв банкны зорилтод нийцтэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулснаар бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанканд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдод ирээдүйн талаар мэдээлэл өгөх, хүлээлтийг удирдах ач холбогдолтой.

Монголбанкны мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт нь банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүгийн нэгдсэн бодлого, репо санхүүжилт болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг ашиглаж байна. Мөнгөний бодлогын шилжих механизм ёсоор банк хоорондын захын хүүгийн өөрчлөлт нь хадгаламж, зээлийн хүү болон бусад хөрөнгийн үнэд нөлөөлснөөр инфляц болон тэдгээрийн ирээдүйн төлөвийн талаарх хүлээлтэд нөлөөлдөг. Ингэхдээ бодлогын хэрэгсэл нь эцсийн зорилт болох эдийн засгийн идэвхжил, инфляцад тодорхой хугацааны хоцролттой нөлөөлдөг.

Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү, банкуудын эх үүсвэрийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болж байна. Түүнчлэн бодлогын хүүгийн коридор системтэй уялдуулан мөнгөний бодлогын бусад хэрэгслүүдийн хүү тодорхойлогдож байна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2023 оны 5-р сарын 31 болон 6-р сарын 23-ны өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

Мөнгөний бодлогын 2023 оны 6-р сарын 23-ны өдрийн мэдэгдлийн дэлгэрэнгүйг [эндээс](#) уншина уу.

Инфляцын тайланд орсон тоон өгөгдөл, зураг, хүснэгтийг [дараах](#) линкээр орж татан авах боломжтой.

© Монголбанк 2023

ТОЙМ

Дэлхийн эдийн засгийн төлөв сайжирсан хэдий ч тодорхой бус байдал өндөр хэвээр үргэлжлэхээр байна. Манай гадаад эрэлтийн төлөвийг голлон тодорхойлогч өмнөд хөршийн эдийн засгийн идэвхжил сайжирч, экспортын гол нэрийн барааны үнийн төсөөлөл өмнөхөөс нэмэгдэв. Дэлхий дахинд нийлүүлэлтийн доголдол намжиж, газрын тосны үнэ буурсан нь улс орнуудад инфляцын түвшин саарах, эдийн засгийн идэвхжил сэргэхэд эергээр нөлөөллөө. Гэвч, улс орнуудын хооронд үүссэн геополитикийн асуудал, АНУ, Европ зэрэг томоохон эдийн засагтай улсуудын банк, санхүүгийн зах зээлийн хүндрэл, төв банкуудын хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлого нь тодорхой бус байдлын гол эх сурвалж болж, дэлхийн эдийн засагт сөргөөр нөлөөлж болзошгүй. Түүнчлэн, БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын өсөлтийн төлөв саарах эрсдэлтэй байгааг олон улсын шинжээчид анхааруулж байна. Энэ удаагийн эдийн засгийн төсөөлөл, бодлогын шинжилгээнд 2023 оны 6 дугаар сард батлагдсан төсвийн тодотголын нөлөөг тусгаагүй бөгөөд дараах хэсэгт эдийн засгийн төлөвийг тоймлон хүргэж байна.

Инфляцын төсөөлөл эрэлтийн бус хүчин зүйлсийн нөлөөгөөр өмнөх төсөөлөлтэй харьцуулахад нэмэгдлээ. Инфляцын түвшин 2023 оны 5 дугаар сард улсын хэмжээнд 11.3 хувь, Улаанбаатар хотод 10.8 хувьд хүрч алгуур буурах хандлага үргэлжилж байна. Гэвч, нийлүүлэлтийн шалтгаанаас үүдэлтэй мах, махан бүтээгдэхүүний үнэ сүүлийн саруудад хүлээлтээс өндөр өссөн, үүнийг даган үйлчилгээний инфляц нэмэгдсэн болон импортын барааны үнэ буурах хурд хүлээлтээс удаан байна. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляцын төсөөлөл өмнөхөөс нэмэгдсэнээр инфляц энэ оны эцэст нэг оронтой тоонд, ирэх оны эхний хагаст зорилтын дээд хязгаарт ирж тогтворжихоор байна. Гэхдээ, төсвийн тодотголтой холбоотойгоор ирэх улирлуудад төсвийн зардал, тэр дундаа цалин, тэтгэвэр тэтгэмж хүлээлтээс өндөр өсөхөөр байна.

2023 оны эдийн засгийн өсөлтийн төлөвийг өмнөх төсөөллөөс бага зэрэг сайжруулав. Энэ оны эхний улиралд эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр гарахад уул уурхай болон түүнээс хамааралтай тээвэр, худалдааны салбаруудын идэвхжил нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. Тодруулбал, БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогын арга хэмжээ суларсантай холбоотойгоор нүүрс, зэсийн баяжмалын экспорт хүлээлтээс сайн гарч, уул уурхайн салбарын өсөлтийг дэмжлээ. Гэвч, уул уурхайн бус салбарын өсөлт хүлээлтээс бага гарч, цаашдын төлөв саарах хандлагатай боллоо. Тухайлбал, цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас хөдөө аж ахуйн салбар, түүнийг дагасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурах хүлээлттэй байна. Хөдөлмөр харьцангуй ихээр шингээдэг эдгээр салбаруудын өсөлт удаашрах нь хөдөлмөрийн зах зээлийн төлөвийг муутгахын зэрэгцээ өрхийн хэрэглээ, дотоод эрэлтийг агшааснаар үйлчилгээний салбарын өсөлт удааширах эрсдэлтэй байна.

Нэгдсэн төсвийн 2023 оны 5 дугаар сарын гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн тэнцэл 1.4 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Эдийн засгийн идэвхжил, экспортын огцом өсөлтийг даган төсвийн тэнцвэржүүлсэн орлого сайн байж өмнөх оны мөн үеэс 43.2 хувиар нэмэгдэж 8.5 их наяд төгрөгт хүрэв. Тодруулбал, аж ахуй нэгжийн орлогын албан татвар болон ашигт малтмал нөөц ашигласны төлбөрийн орлого бүрдүүлэлт өндөр байлаа. Харин төсвийн нийт зардал энэ оны эхний 5 сард 7.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 9.7 хувиар өсөв.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт энэ оны эхний улиралд эрчимжсэн бол банкны системийн зээлийн өсөлт нам түвшинд байна. 2023 оны эхний улиралд төлбөрийн тэнцэл ашигтай байж, банкны системийн гадаад цэвэр актив нэмэгдсэнээр М2 мөнгөний нийлүүлэлт эрчимжсэн бол 4 дүгээр сард арилжааны банкуудын гадаад актив буурснаар М2 мөнгөний өсөлтийн хурд саарав. Банкны системийн эх үүсвэр талаас гадаад валютын харилцах дансны өөрчлөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голчлон тайлбарлаж байна. Банкны системийн зээл өнгөрсөн оны сүүлийн улирлуудад хурдацтай саарч байсан бол энэ оны эхний 4 сарын байдлаар нам түвшинд тогтвортой байна. Зээлийн зориулалтаар нь авч үзвэл хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл өсөлттэй байгаа бол бизнесийн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад хумигджээ.

Дэлхийн эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс нэмэгдэв. Үүнд, БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогын хязгаарлалт суларснаар тус улсын үйлчилгээний салбарын өсөлт 2023 оны I улиралд хүлээлтээс хурдтай сэргэсэнээс гадна нийлүүлэлтийн сүлжээний доголдол харьцангуй сайжирч, тээврийн зардал буурч байгаа нь голлон нөлөөлсөн байна. Гэвч, ОХУ-Украины нөхцөл байдалтай холбоотой тодорхой бус байдал болон АНУ, Европын холбоо зэрэг томоохон эдийн засагтай улсуудын банк, санхүүгийн зах зээлд үүсээд буй хүндрэл цаашид даамжрах эрсдэл нь өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Төлбөрийн тэнцэл 2023 оны эхний улиралд 80 сая ам.долларын ашигтай гарлаа. Нүүрсний экспортын биет хэмжээ 2023 оны I улиралд түүхэн дээд түвшинд хүрч нэмэгдсэн нь экспортын орлогыг тэтгэсэнээс гадна хэрэглээний бүтээгдэхүүний импорт буурснаар урсгал тэнцлийн алдагдал буурав. Гэхдээ хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортын өсөлт, үйлчилгээний дансны алдагдал өндөр хэвээр хадгалагдаж байна.

1. ИНФЛЯЦ


1.1. Инфляцын цаашдын төлөв

Төсөөлөлд ашигласан гол таамаглалт нөхцөлүүд:

- Бодлогын хүүг 2023 оны 2, 3 дугаар улиралд 13 хувьд хэвээр хадгалах;
- Нийлүүлэлтийн доголдол болон хилийн хязгаарлалт үүсэхгүй.
- АИ-92 шатахуун авах гэрээний үнэ өөрчлөгдөхгүй.
- Төрийн зохицуулалттай бараа үйлчилгээний үнэ энэ онд өсөхгүй.
- Цаг агаарын нөхцөл байдал хэвийн байх гэсэн таамаглалт нөхцлүүдэд үндэслэн төсөөллийг боловсрууллаа.

Инфляцын төсөөлөл эрэлтийн бус хүчин зүйлсийн нөлөөгөөр өмнөх төсөөллөөс нэмэгдлээ. Үүнд, сүүлийн саруудад махны үнэ эрчтэй өссөн, үүнийг даган үйлчилгээний инфляц өмнөх төсөөллөөс нэмэгдсэн болон импортын барааны үнийн өсөлт саарах хурд хүлээлтээс удаан байгаа зэрэг нь голлон нөлөөлөв. Тодруулбал, энэ оны эхний хагаст махны экспорт огцом нэмэгдсэний зэрэгцээ өвөлжилт хүндэрч малын зүй бус хорогдол өссөн нь махны нийлүүлэлтийг бууруулж, үнэ өсөхөд нөлөөллөө. Мах, гурил зэрэг хүнсний үнэ өссөнөөр орцын зардал нэмэгдэж, үйлчилгээний инфляц өмнөх төсөөллөөс нэмэгдэв. Мөн ачаа барааны тээвэрлэх хугацаа болон зардал буурч, төгрөгийн ханш бага зэрэг чангарч байгаа хэдий ч импортын инфляцын буурах хурд хүлээлтээс удаан байгаа зэрэг нь инфляцын төсөөллийг өсгөх гол хүчин зүйл боллоо. Цаашид дотоод эрэлт сайжрах, гадаад инфляц өмнөх төсөөллөөс бага зэрэг өссөнөөр инфляцын төсөөлөл нэмэгдлээ.

Зураг 1.1 Инфляцын өмнөх болон одоогийн төсөөлөл



Эх сурвалж: Монголбанк

Инфляц 2023-2025 оны эцэст харгалзан 8.9 хувь, 7.4 хувь, 6.8 хувь байх төсөөлөлтэй байна. Уул уурхайн бус салбарын сэргэлт удааширч, эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт энэ онд багасах бол нийлүүлэлт, зардлын шалтгаантай үнийн өсөлт инфляцыг нэмэгдүүлсэн хэвээр байна. Тодруулбал, махны үнэ сүүлийн саруудад эрчтэй өсөж, цаашид улирлын хандлагаа даган алгуур буурах хүлээлттэй байна. Хүнсний үнийн өсөлтийг даган үйлчилгээний үнэ ирэх саруудад нэмэгдэх хүлээлттэй болов. Харин дизель түлшийг онцгой албан татвараас чөлөөлснөөс гадна АИ-92 шатахууныг хөнгөлөлттэй үнээр худалдан авах гэрээ 3 дугаар сард шинэчлэгдэж, хилийн үнэ буурсан нь шатахууны инфляцыг бууруулах нөлөө үзүүлэхээр байна.

Хүснэгт 1.1 Инфляцын төсөөлөл

	2022.I	2023*	2024*	2025*
		төсөөлөл		
Инфляц ¹	12.1	8.9 [7.4-10.4] ²	7.4 [5.6-9.2]	6.8 [5.5-8.2]

Эх сурвалж: Монголбанк

Дунд хугацаанд гадаад үнэ тогтворжих, ханш бага зэрэг чангарснаар импортын бараа, үйлчилгээний инфляц алгуур буурах төлөвтэй байна. Хүнсний инфляцын хувьд

¹ ХҮИ-ээр хэмжигдэх инфляц, 4 дүгээр улирлын дундаж

² 30 хувийн магадлалтай итгэх интервал

дэлхийн зах зээл дээрх хүнсний үнэ буурах, нийлүүлэлтийн доголдол арилах зэрэг нөлөөгөөр буурч, 2024 оны 2 дугаар улирлаас нэг оронтой тоонд хүрч тогтворжих төлөвтэй байна. Ийнхүү нийт инфляц энэ оны эцэст Төв банкны зорилтын дээд хязгаарт ирж, цаашид алгуур буурах хүлээлттэй боллоо.

Инфляцын төсөөллийг өөрчилж болзошгүй тодорхой бус байдал:

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
Төсвийн зардал энэ онд огцом тэлж байгаа нь импортын бараа, бүтээгдэхүүн, цаашлаад дотоодын барааны үнийг өсгөх, инфляцыг нэмэгдүүлэх дарамтыг бий болгож байна.	Өндөр	Дунд (өсгөх)
Бодит худалдан авах чадвар буурч байгаа нь цалин өсөх шаардлагыг нэмэгдүүлж, улмаар үнэ-цалин ээлжлэн өсөх үзэгдэл даамжрах эрсдэлийг бий болгож болзошгүй.	Дунд	Дунд (өсгөх)
Геополитикийн нөхцөл байдал илүү хурцдах, улс хоорондын хязгаарлалтууд зэргээс үүдэн нийлүүлэлтийн сүлжээний доголдол даамжирвал тээврийн зардал өсөж, улмаар импортын бараа, бүтээгдэхүүний үнээр дамжин инфляцыг нэмэгдүүлж болзошгүй.	Дунд	Өндөр (Өсгөх)
Цаг агаарын нөхцөл муудах, нийлүүлэлтийн гэнэтийн шок үүсвэл мах, хүнсний ногооны үнэ өөрчлөгдөх, мөн төрийн зохицуулалттай бараа бүтээгдэхүүний үнэ төсөөллөөс өөрчлөгдөх зэрэг нь инфляцыг хэлбэлзүүлэх магадлалтай.	Дунд	Дунд

³ Монголбанкны Судалгаа статистикийн газраас улирал бүр боловсруулдаг “Инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа”-ны тайланд үндэслэв.

⁴ Санал асуулгад оролцсон хүмүүсээс инфляцын хүлээлтийг тоон утгаар асууж дунджилж гаргасан.

⁵ Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцсон. Энэ аргачлал нь түүвэр судалгаанд оролцогчдын хариултуудыг

Инфляцын богино хугацааны хүлээлт буурав³.

Сүүлийн саруудад үнийн өсөлт тогтворжиж байгаатай холбоотойгоор иргэдийн инфляцын богино хугацааны хүлээлт буурч байна. 2023 оны 1 дүгээр улирлын түүвэр судалгаагаар иргэдийн инфляцын хүлээлт өмнөх улирлаас буурав (Хүснэгт 1.2).


Хүснэгт 1.2 Инфляцын хүлээлт

	2023.I	2023.IV
Тоон хариулт ⁴	10.2	9.8
Чанарын хариулт ⁵	11.7	10.9
Мэдрэмжид суурилсан арга ⁶	7.4	8.5

Эх сурвалж: Монголбанк

Инфляцын чиглэлийн индекс буюу иргэд инфляц өсөх, буурахыг хэрхэн хүлээж байгааг илтгэдэг уг индекс өмнөх улирлаас нилээд буурч “инфляц хэвэндээ байна” муж руу шилжсэн бөгөөд иргэд ирэх 3 сард инфляц хэвэндээ байна гэж хүлээж байна (Зураг 1.2).

Зураг 1.2 Үнийн өсөлтийн талаарх хандлага (чиглэлийн индекс, 3 сар)




Эх сурвалж: Монголбанк

магадлалын функц ашиглан тоон утганд хөрвүүлж, хүлээлтийг тооцдог.

⁶ Түүвэр судалгаанд оролцогчдын хариултаас мэдрэгдсэн үнийн өсөлтийг одоогийн инфляцтай уялдуулж, ирээдүйн хүлээлтийг тооцдог арга.

Зураг 1.5 Улаанбаатар хотын жилийн инфляц бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: УСХ, Монголбанк

1.3. Төсөөллийн зөрүү

Энэ оны I улирлын дундаж инфляц төсөөллийн орчимд буюу 12.1 хувь байв. Дэлгэрүүлбэл, хүнсний бүлгийн үнэ төсөөллөөс багаар буюу 13.8 хувиар нэмэгдсэн. Харин хүнсний бус бүлгийн үнэ төсөөллөөс бага зэрэг илүү байж 11.4 хувь өсөхөд импортын бараа, үйлчилгээний үнэ хүлээлтээс ялимгүй өндөр өссөн байна.

2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

2.1. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв

Төсөөлөлд ашигласан гол таамаглалт нөхцөлүүд:

- Бодлогын хүүг 2023 оны 2, 3 дугаар улиралд 13 хувьд хэвээр хадгалах;
- Нүүрсний экспортын биет хэмжээ 2023-2025 онд өмнөх төсөөллөөс 3.5 сая.тн-оор нэмэгдэх;
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт орох урсгал 2023 онд 154 сая ам.доллараар өмнөх оноос өсөх, 2024 онд 535 сая ам.доллар, 2025 онд 526 сая ам.доллараар өмнөх оноос буурах;
- Олон улсын байгууллагуудын донор санхүүжилт 2023 онд 149 сая ам.доллар, 2024 онд 51 сая ам.доллар, 2025 онд 124

сая ам.доллараар өмнөх оноос буурах, төсвийн дэмжлэг 2023 онд 200 сая ам.доллараар өмнөх оноос нэмэгдэх, 2024 онд 200 сая ам.доллараар өмнөх оноос буурах, 2025 онд өөрчлөлтгүй;

- "2023-2024 онд Хөөт-Бичигт чиглэлийн 236 км төмөр зам баригдах"-аас өөр мега төсөл хэрэгжихгүй;
- Нийлүүлэлтийн доголдол болон хилийн хязгаарлалт байхгүй.

Эдийн засгийн өсөлт 2023 онд 4.2 хувь, 2024 онд 5.2 хувь, 2025 онд 5.0 хувьд хүрэх тооцоололтой байна (Хүснэгт 2.1). Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг нийлүүлэлт болон эрэлт талаас задлан доор тайлбарлав.

Хүснэгт 2.1 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл⁸

	2022	2023*	2024*	2025*
		төсөөлөл		
ДНБ-ий өсөлт	4.8	4.2 [2.4-6.0]	5.2 [2.7-7.8]	5.0 [2.3-7.9]
Уул уурхай	-11.9	19.0 [17.2-20.8]	9.0 [6.0-11.6]	21.6 [18.8-24.4]
Уул уурхайн бус	7.5	2.3 [0.5-4.1]	4.6 [2.1-7.2]	2.4 [-0.4-5.2]


Эх сурвалж: Монголбанк

Нийт нийлүүлэлт

Нийт үйлдвэрлэлийн 2023 оны өсөлтийн төсөөллийг 4.2 хувьд хүргэж өмнөх төсөөллөөс бага зэрэг нэмэгдүүлээ (Зураг 2.1). Үүнд, гадаад эрэлтийн төлөв сайжран нүүрс, зэсийн баяжмалын экспорт нэмэгдэж, уул уурхайн салбарын өсөлтийн төлөв өмнөхөөс сайжрах, үүнийг дагаад тээвэр, худалдааны салбарын өсөлт нэмэгдэхээр байгаа нь гол нөлөөг үзүүлж байна. Дунд хугацаанд уул уурхайн үйлдвэрлэл идэвхжсэнээр уул уурхайн бус салбар, улмаар нийт эдийн засгийн өсөлтийг дэмжинэ гэж үзлээ.

⁸ 30 хувийн магадлалтай итгэх интервал

Зураг 2.1 4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Уул уурхайн бус салбар: Уул уурхайн бус салбар энэ онд 2.3 хувиар өсөхөөр авч үзсэн. Үүнд тээвэр, худалдааны салбарын үйлдвэрлэл голлох эерэг нөлөөг үзүүлэхээр байна. Харин малын зүй бус хорогдол нэмэгдсэнээр хөдөө аж ахуйн салбарын өсөлт буурах, хүнс болон барилгын материалын боловсруулах үйлдвэрлэл агшихаар хүлээгдэж байгаа нь уул уурхайн бус салбарын өсөлтийг бууруулах төлөвтэй. Түүнчлэн өрхийн хэрэглээ саарах хандлагатай болсон нь бусад үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татварын орлогод сөргөөр нөлөөлж, эдгээр салбаруудын өсөлт өмнөх төсөөллөөс бага зэрэг буурах хүлээлттэй боллоо. Ирэх онд уул уурхайн бус салбаруудын хувьд, төсвийн төлөв сулрах, гадаад эрэлт сайжрах болон уул уурхайн салбарын эерэг дам нөлөөгөөр урт хугацааны тэнцвэрт түвшин рүүгээ дөхөж өсөх таамаглалтай бол 2025 онд төсвийн төлөв чангарах, хөрөнгө оруулалт хумигдахаар байгаа нь өсөлтийн төсөөллийг бага зэрэг бууруулахаар байна.

Нийт эрэлт

Нийт эрэлтийн 2023 оны өсөлтийн төсөөллийг 4.2 хувьд хүргэж өмнөх төсөөллөөс 0.2 нэгж хувиар нэмэгдүүлэв (Хүснэгт 2.2). Үүнд, алт, зэс, нүүрс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өмнөх төсөөллөөс нэмэгдсэн, нефтийн бүтээгдэхүүний үнэ өмнөх төсөөллөөс буурснаар шатахуун импортлох зардал буурсан зэрэг нь цэвэр экспортод эерэг нөлөө үзүүлж, нийт эрэлтийн төсөөлөл өмнөхөөс сайжрахад нөлөөлөв. Ирэх жилүүдэд цэвэр экспорт нийт эрэлтийг тэтгэх хүлээлттэй байна.

Дотоод эрэлт: Энэ онд өрхийн хэрэглээ саарч, хөрөнгийн нийт хуримтлал агших нөлөөгөөр дотоод эрэлтийн өсөлт өмнөх оноос саарах төлөв хадгалагдаж байна. Хөрөнгийн нийт хуримтлал өмнөх оноос агшихад өмнөх оны өндөр өсөлттэй байсан суурь үеийн нөлөөнөөс гадна хилийн хязгаарлалт, тээврийн саатал арилснаар материаллаг эргэлтийн хөрөнгийн хуримтлал буурч байгаа нь гол нөлөөг үзүүлэхээр байна. Түүнчлэн, санхүүгийн нөхцөл чангарснаас үүдэн бизнесийн зээлийн өсөлт саарч, хувийн хөрөнгө оруулалт буурсан нь хөрөнгийн нийт хуримтлалыг бууруулахаар байна.

Өрхийн хэрэглээний өсөлт энэ онд нам түвшинд байх хүлээлттэй байна. Сүүлийн 5 улирал дараалан эрчимтэй өссөн өрхийн хэрэглээ тайлант улиралд өмнөх оны мөн үеэс буурлаа. Цаашид цалин, тэтгэвэр өссөнөөр өрхийн хэрэглээ нэмэгдэх хүлээлттэй байгаа ч хөдөлмөр эрхлэлт болон бодит орлогын өсөлт буурах, ипотекийн зээлийн эргэн төлөлт хийгдэж байгаа зэрэг нь өрхийн хэрэглээнд сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Цэвэр экспорт: Экспортын өсөлт энэ онд импортын өсөлтийг давж цэвэр экспорт сайжрах хүлээлттэй байна. Тодруулбал,

нүүрс, зэс, газрын тос, төмрийн хүдэр, мах махан бүтээгдэхүүний экспорт өмнөх оноос нэмэгдэхийн зэрэгцээ гол нэрийн экспортын түүхий эдийн үнийн төсөөлөл нэмэгдсэн нь экспортыг нэмэгдүүлэх гол нөлөө үзүүлэхээр байна. Нөгөө талаас уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг дагаад машин тоног төхөөрөмжийн импорт, тээврийн зардал нэмэгдэн үйлчилгээний импорт тэлэх хандлагатай байгаа бол төмөр замын том бүтээн байгуулалтын ажил дууссанаар бусад хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурах, өрхийн хэрэглээ, уул уурхайн бус салбарын идэвхжил суларснаар хэрэглээ болон аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт буурах төлөвтэй байна. Ирэх жилүүдэд уул уурхайн салбарын идэвхжлийг даган эрдэс бүтээгдэхүүний экспорт нэмэгдэх, түүхий эдийн үнэ өмнөх оноос буурах ч харьцангуй өндөр түвшинд хадгалагдах, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт саарах зэрэг нь цэвэр экспортыг өсгөх хүлээлттэй байна.

Хүснэгт 2.2 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, өсөлтийн бүрэлдэхүүнээр

	2022	2023*	2024*	2025*
		<i>төсөөлөл</i>		
ДНБ-ий өсөлт	4.8	4.2	5.2	5.0
Дотоод эрэлт	12.7	-0.5	-2.5	-5.4
Цэвэр экспорт	-7.8	4.7	7.7	10.5

Эх сурвалж: Монголбанк


Эдийн засгийн цаашидын төлөвт нөлөөлж болзошгүй тодорхой бус байдал

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
БНХАУ-ын Тэг-Ковид бодлогын хязгаарлалт суларч, аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэнээр манай улсын нүүрсний экспорт сүүлийн саруудад эрчимжив. Гэвч тус салбарын идэвхжил хүлээлтээс бага байгаа нь тодорхой бус байдлыг үүсгэж байна. Хятадын талаас нүүрс татан авалтаа эрс багасгах нөхцөлд манай улсын экспортын орлогод сөргөөр нөлөөлж, тээвэрлэлт буурч, эдийн засгийн өсөлтийг муутгах эрсдэлтэй.	Өндөр	Өндөр (сөрөг)
Инфляц өссөнтэй зэрэгцэн цахилгаан, дулаан, орон сууцны зээлийн төлбөрүүд үе шаттай төлөгдөж эхэлснээр өрхийн хэрэглээ саарах хандлага бий боллоо. Энэхүү нөхцөл байдал удаан хугацаанд үргэлжилвэл эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлж, өсөлтийг удаашруулах эрсдэлтэй.	Дунд	Дунд (сөрөг)
АНУ, Европ зэрэг томоохон эдийн засагтай орнуудад үүсээд буй банк, санхүүгийн хямрал нь хөрөнгө оруулагчдын итгэлийг муутгаж, дэлхийн эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж эхэлсэн. Хэрвээ энэ нөхцөл байдал хурцадвал санхүүгийн нөхцөл хүлээлтээс хурдтай чангарч, хөрөнгийн урсгал татрах, зээл, санхүүжилтийн боломж хумигдах, эх үүсвэрийн зардал нэмэгдэх зэрэг эрсдэл үүснэ.	Бага	Дунд (сөрөг)
Геополитикийн хурцадмал нөхцөл байдал үргэлжилж, ОХУ-Украины дайны явц даамжирч байгаа нь дэлхийн эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж, аж үйлдвэрийн салбар удаахрах эрсдэл хэвээр байгаа нь эрдэс бүтээгдэхүүний эрэлт, үнийг бууруулж болзошгүй байна. Нөхцөл байдал төсөөллөөс муудвал манай улсын экспортын орлого буурах, төлбөрийн тэнцлийн алдагдал тэлэх, төсвийн орлого төлөвлөгөөнөөс дутах, эдийн засгийн өсөлтийн төлөвийг муутгах эрсдэлтэй.	Дунд	Дунд (сөрөг)

Потенциал үйлдвэрлэл

Бүс нутагт үүссэн геополитикийн нөхцөл байдал гадаад орчин талаас тодорхой бус байдал дагуулсан хэвээр байна. Уул уурхайн салбарын сэргэлт үргэлжлэх нөлөөгөөр зарим салбаруудын идэвхжил нэмэгдэн нийт потенциал үйлдвэрлэлийн өсөлт нэмэгдэх хандлагатай боллоо (Зураг 2.2).

Зураг 2.2 Потенциал үйлдвэрлэлийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк


Эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн мэдээллийг ашиглан тооцдог олон хувьсагчийн Калман фильтр, нэг хувьсагчийн HP фильтр болон Үйлдвэрлэлийн функцын аргачлалаар тооцсон потенциал үйлдвэрлэлийн өсөлт цар тахлын өмнөх үе рүү дөхөж өсөх хандлагатай байна. Үйлдвэрлэлийн функцын аргачлалаар тооцсон потенциал үйлдвэрлэлийн өсөлтөд капитал хуримтлал голлох эерэг нөлөө үзүүлсэн хэвээр байна. Бүтээмжийн сөрөг нөлөө буурч байгаа бол хөдөлмөрийн орцын эерэг нөлөө багасах хандлагатай болж байна.

Үйлдвэрлэлийн зөрүү

Хилийн хязгаарлалт суларч, БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил нэмэгдсэн нь нүүрсний экспортод эерэг нөлөө үзүүлж, уул уурхайн үйлдвэрлэлийн сөрөг зөрүү тайлант улиралд үргэлжлэн буурлаа. Харин

уул уурхайн бус салбар өнгөрсөн оны эхнээс 4 улирлын турш сэргэн үйлдвэрлэлийн сөрөг зөрүү хаагдаж байсан бол тайлант улиралд энэ хандлага эсрэг чиглэлд өөрчлөгдлөө. Үүнд тээвэр, худалдаанаас бусад салбаруудын идэвхжил буурсан, тэр дундаа цаг агаарын таагүй байдлаас үүдэлтэй хөдөө аж ахуйн салбарын бууралт гол нөлөөтэй байв. Ийнхүү уул уурхайн бус үйлдвэрлэл саарах, уул уурхайн салбарын идэвхжил нэмэгдэж байгаа ч хараахан потенциал түвшиндээ хүрээгүй зэргээс үүдэн нийт үйлдвэрлэлийн зөрүү сөрөг хэвээр байна (Зураг 2.3).

Зураг 2.3 Үйлдвэрлэлийн зөрүү⁹



Эх сурвалж: Монголбанк

2.2. Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл

Эхний улирлын эдийн засгийн өсөлтийг тоймлон авч үзвэл:

- Эрдэс бүтээгдэхүүний экспорт эдийн засгийн өсөлтийг тэтгэв;
- Дотоод эрэлт муудаж, уул уурхайгаас хамаарал бага салбаруудын идэвхжил удааширч байна;
- Өвөлжилт хүндэрч хөдөө аж ахуйн салбар агшив.


Нийт эрэлт

Нийт эрэлт энэ оны I улиралд 7.8 хувиар өслөө. Уул уурхайн экспорт эрчтэй өсөж эрэлтийг голлон дэмжсэн бол дотоод эрэлт (эцсийн хэрэглээ, хөрөнгийн хуримтлалын

⁹ GAP загварын үр дүн

нийлбэр) 7 улирлын дараагаар уналттай гарав (Зураг 2.4).


Зураг 2.4 Эцсийн хэрэглээ болон экспорт нийт эрэлтийг дэмжиж байна



Нийт эрэлт I улиралд 7.8 хувь өссөнийг гол бүрэлдэхүүнүүдээр дэлгэрүүлбэл:

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрсний биет хэмжээ 5.5 дахин, төмрийн хүдэр 2 дахин нэмэгдсэн нь цэвэр экспортын өсөлтийг голлон бүрдүүлж байна. Тухайлбал, нүүрсний экспорт I улиралд 13.8 сая тоннд хүрсэн нь нэг улиралд экспортолсон түүхэн дээд хэмжээ болов (Зураг 2.5).


Зураг 2.5 Нүүрсний тээвэрлэлт хэвийн үргэлжилж байна



Өмнөх оны турш өсөлттэй байсан өрхийн хэрэглээ тайлант улиралд агшсан байна. Үүнд 1) хөдөлмөр эрхлэлтийн түвшин 3

улирал дараалан буурч, сүүлийн 7 улирлын доод түвшинд хүрсэн, 2) өрхийн орлого дахь цалин жилийн 28 орчим хувиар нэмэгдсэн ч бусад орлого 12 хувиар буурсан зэргээс өрхийн нэрлэсэн орлогын өсөлт удааширсан нь нөлөөлсөн байж болохоор байна (Зураг 2.6).


Зураг 2.6 Өрхийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс агшив



Материаллаг эргэлтийн хөрөнгийн хувьд өвөлжилт хүндэрч малын зүй бус хорогдол нэмэгдсэн, төл бойжилт муу, түүхий эдийн экспорт таамаглалаас давсан зэргээс өмнөх оны мөн үеэс 71 орчим хувиар буурлаа.

Нөгөө талаас хөрөнгө оруулалт төсвийн батлагдсан дүнтэй харьцуулахад эхний улиралд 56 орчим хувийн гүйцэтгэлтэй зарцуулагджээ. Мөн үндсэн хөрөнгийн хуримтлалын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг барилга байгууламж, машин тоног төхөөрөмжийн өртөг дунджаар 30-40 хувь нэмэгдсэн зэргээс хөрөнгийн нийт хуримтлал тайлант улиралд 26.5 хувиар буурч, нийт эрэлтийн өсөлтөд 10.4 нэгж хувийн сааруулах нөлөө үзүүлэв (Зураг 2.7). Ийнхүү хөрөнгө оруулалтын орчин өнгөрсөн улирлаас муудаж, хөрөнгийн нийт хуримтлалын эдийн засагт үзүүлэх нөлөө 2021 оноос хойших хамгийн бага түвшинд хүрлээ.

Зураг 2.7 Хөрөнгө оруулалтын орчин сэргээгүй байна




Эх сурвалж: YCX, Монголбанк

Нийт нийлүүлэлт

Нийт үйлдвэрлэл 2023 оны I улиралд 7.9 хувиар өссөн байна. Уул уурхай болон түүнээс хамааралтай тээвэр, худалдааны салбарууд эдийн засгийн өсөлтийг тэтгэж байгаа бол бусад салбарууд удааширах төлөв ажиглагдав (Зураг 2.8). Ялангуяа өрхийн хэрэглээний эрэлт удааширсантай зэрэгцэн түргэн эдэлгээт бараа, бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэл, татварын орлого бүрдүүлэлт мууджээ. Мөн өвөлжилт хүндэрч хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл агшсан байна.

Зураг 2.8 Нийт үйлдвэрлэлийн өсөлтийн бүрэлдэхүүн, 2019-2023.I улирал




* - Боловсруулах, эрчим хүч, барилга, мэдээлэл холбоо, бусад үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татвар

Эх сурвалж: YCX

Тайлант улиралд нүүрс, зэсийн баяжмал, газрын тосны үйлдвэрлэл, тээвэр хэвийн үргэлжилж уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтөд 5.3 нэгж хувийг дангаар бүрдүүлэв. Тодруулбал, өнгөрсөн оны I улиралтай харьцуулахад олборлосон нүүрс 3.3 дахин, нүүрсний экспорт 5.5 дахин нэмэгдсэний зэрэгцээ Оюу Толгойн далд уурхайн олборлолт эхэлснээр зэсийн баяжмалын үйлдвэрлэл 40 хувиар өсжээ (Зураг 2.9).

Зураг 2.9 Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрчимжив




Эх сурвалж: YCX, Монголбанк

Ийнхүү уул уурхайн бүтээгдэхүүний экспорт хэвийн үргэлжилж, манай улсаар дамжин өнгөрөх төмөр замын транзит ачаа тээвэр бүрэн сэргэснээр тээврийн салбар жилийн 76 хувиар өссөн байна.

Харин дотоод эрэлт муудаж, өвөлжилт хүндэрснээр аж үйлдвэр, үйлчилгээ, мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл удааширлаа (Зураг 2.10). Ялангуяа өнгөрсөн онд тогтвортой сэргэсэн малын ашиг шимийн бүтээгдэхүүн, барилгын материалын үйлдвэрлэл, боловсруулалт саарав. Үүнээс гадна энэ оны эхнээс согтууруулах ундаанд ноогдуулах онцгой албан татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэнтэй зэрэгцэн тус төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, татвар бүрдүүлэлт бага дүнтэй байлаа.

Зураг 2.10 Аж үйлдвэр, үйлчилгээ болон хөдөө аж ахуйн салбарын жилийн өсөлт



Эх сурвалж: YCX, Монголбанк

Хөдөө аж ахуйн салбарын хувьд I улиралд 5.1 хувиар буурч, эдийн засгийн өсөлтөд 0.2 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлэв. Тухайлбал, баруун болон зүүн бүс нутгаар өвөлжилт муудаж, өнгөрсөн оны мөн үеэс мал төллөлт бага, зүй бус хорогдол нэмэгджээ. Оны эхнээс нийт 960 мянган мал хорогдсоноос Увс (174 мянга), Баянхонгор (108 мянга), Архангай (141 мянга) аймагт хорогдлын хувь хамгийн өндөр байна.

3. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

3.1. Хөдөлмөрийн зах зээл


Хөдөлмөрийн захын I улирлын төлөвийг тоймлон авч үзвэл:

- Ажиллах хүчний оролцооны түвшин үргэлжлэн буурав.
- Бодит цалин жилийн өмнөх үеэс 12.7 хувиар өсөж,
- Нэгж хөдөлмөрийн зардал нэмэгдэж байна.

Өмнөх 4 улиралд өсөөд байсан хөдөлмөрийн насны хүн амын тоо тайлант улиралд бууралттай (-0.9%) гарлаа. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам нэмэгдсэн бол ажилтай болон

ажилгүй хүмүүсийн тоо буурсан нь үүнд нөлөөлжээ (Зураг 3.1).


Зураг 3.1 Ажиллах хүчнээс гадуурх хүн ам нэмэгдэж, ажиллагчид болон ажилгүй иргэд буурав.



Эх сурвалж: YCX

Мөн энэ оны I улиралд тэтгэвэр авагчдын тоо нэмэгдсэн нь ажиллах хүчнээс гадуурх хүн амын өсөлтийн гол шалтгаан болов. Ингэснээр сүүлийн 2 улиралд дараалан ажиллах хүчнээс гадуурх хүн ам нэмэгдлээ (Зураг 3.2).

Зураг 3.2 Ажиллах хүчнээс гадуурх хүн ам нэмэгдэв.



Эх сурвалж: YCX

Ажиллах хүчний оролцооны түвшин тайлант улиралд 56.5 хувьд хүрч буурсан нь өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар доогуур үзүүлэлт боллоо. Түүнчлэн, хөдөлмөр дутуу ашиглалтын нийлмэл түвшин 9.4 хувь, ажилгүйдлийн түвшин 6.6 хувь болж өмнөх оны мөн үеэс харгалзан 2.7 нэгж хувь, 1.8 нэгж хувиар буурав (Зураг 3.3).


Зураг 3.3 Хөдөлмөрийн захын үндсэн үзүүлэлтүүд



Ажил эрхлэлт, нийгмийн даатгал

Нийт ажиллагчдын тооны жилийн өсөлт 2022 оны турш эерэг байсан бол 2023 оны 1-р улиралд 1.5 хувийн бууралттай гарав. Үүнд, боловсруулах, барилга, тээврийн салбарт ажиллагчид буурсан бол худалдаа, уул уурхай, бусад үйлчилгээний салбарт ажиллагчид нэмэгджээ (Зураг 3.4).

Зураг 3.4 Боловсруулах, барилга, тээврийн салбарт ажиллагчид ихээр буурав.




Нийгмийн даатгалд хамрагдагчдын тоо 2023 оны 3-р сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар нэмэгдээд байна. Үүний дийлэнх хэсэг нь хувийн байгууллагын албан журмаар даатгуулагчидтай холбоотой юм.

Цалин, өрхийн орлого

Улсын дундаж болон медиан цалин тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 26 орчим хувиар нэмэгдэж, харгалзан 1'831 болон 1'353 мянган төгрөгтэй тэнцэж байна. Үүний

зэрэгцээ өрхийн сарын дундаж орлого өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар өсөж 1'887 мянган төгрөгт хүрчээ.

Зураг 3.5 Бодит цалин 3 дахь улиралдаа дараалан жилийн өмнөх үеэс нэмэгдэв.



Харин сүүлийн 3 улиралд нэрлэсэн цалин өндөр өсөж, инфляц буурах хандлагатай байгаагаас шалтгаалж бодит цалингийн өсөлт нэмэгдээд байна (Зураг 3.5). Тайлант улиралд бодит цалингийн жилийн өсөлт 12.7 хувьд хүрсэн нь 2013 оны 4-р улирлаас хойших хамгийн өндөр үзүүлэлт юм.


Эдийн засгийн голлох салбаруудаас тээвэр (41%), уул уурхай (38%), төрийн удирдлага (28%)-ын салбарт ажиллагчдын дундаж нэрлэсэн цалин хамгийн өндөр өсөлттэй байв. Харин эрүүл мэнд (18%), боловсрол (20%), худалдаа (20%)-ны салбарт алба хаагчдын цалин хамгийн бага хувиар өсөв.

Нэгж хөдөлмөрийн зардал

Нэгж хөдөлмөрийн зардал¹⁰ нэмэгдэх хандлага тайлант улиралд ч хадгалагдав. Энэ үзүүлэлт сүүлийн 5 улиралд дараалан өсөж байгаа бөгөөд өсөлтийн хурд эрчимжиж байна. Үүний гол шалтгаан нь цалингийн өсөлт болж байна (Зураг 3.6). Өөрөөр хэлбэл цалингийн өсөлт бүтээмжийн өсөлтөөс үлэмж өндөр байгаа нь үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлж үнэ өсөх нэг шалтгаан болж байна.

¹⁰ Нэгж ДНБ-д ногдох дундаж хөдөлмөрийн өртөг буюу цалин.

Зураг 3.6 Нэгж хөдөлмөрийн дундаж зардал өсөж байна.



3.2. Мөнгө, санхүүгийн зах зээл


3.2.1. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2023 оны 1 дүгээр улиралд эрчимжсэн боловч 4 дүгээр сард саарлаа. Харин банкны системийн зээлийн өсөлт нам түвшинд байна.

Мөнгөний нийлүүлэлт 2023 оны 3 дугаар сард 16.7 хувьд хүрч өсөхөд төлбөрийн тэнцэл ашигтай байж, банкны системийн гадаад цэвэр актив (ГЦА) нэмэгдсэн нь голлон нөлөөллөө (Зураг 3.7).


Харин 2023 оны 4 дүгээр сард төлбөрийн тэнцэл ашигтай хэвээр боловч арилжааны банкуудын гадаад активын өөрчлөлтийн¹¹ улмаас банкны системийн ГЦА буурсан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 10 хувьд хүрч саарах гол шалтгаан болов. Тодруулбал, мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтөд ГЦА 2023 оны 3 дугаар сард 10.3 нэгж хувийн нөлөө үзүүлсэн бол 4 дүгээр сард 6.7 нэгж хувийн нөлөөг үзүүлжээ (Зураг 3.7).

Зураг 3.7 М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал



Нэгдсэн төсвийн тэнцэл эхний 4 сарын байдлаар 1.1 их наяд төгрөгийн ашигтай байж Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ)-ийг бууруулах чиглэлд нөлөөтэй байна. Гэхдээ Монгол улсын Засгийн газар “Гэрэгэ” бондын үлдэгдэл 1.2 их наяд төгрөгийн төлбөрийг төлсөн¹² нь ЗГЦЗ 2023 оны 4 дүгээр сард нэмэгдэх хүчин зүйл болов.

Зураг 3.8 М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал



Банкны системийн зээлийн өсөлт сүүлийн саруудад нам түвшинд харьцангуй тогтвортой байж, мөнгөний нийлүүлэлтийн

¹¹ Арилжааны банкуудын гадаадын банк, санхүүгийн байгууллага дах харилцах, хадгаламжийн дүн 300 орчим сая ам.доллараар буурав.

¹² Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сард гадаадын зах зээлд 650 сая ам.долларын “Century-2” бондыг арилжаалж, 2023 оны 1 дүгээр сард “Гэрэгэ” бондын 165

сая ам.доллар, “Хуралдай” бондуудын 209 сая ам.долларыг тус тус дахин санхүүжүүлсэн. Мөн 2023 оны 4 дүгээр сард “Гэрэгэ” бондын үлдэгдэл 367 сая ам.доллар (1.2 их наяд төгрөг)-ын 286 сая ам.долларыг “Century-2” бондын эх үүсвэрээр дахин санхүүжүүлэв.

өсөлтөд эерэг нөлөөтэй хэвээр байна (Зураг 3.8).

Эх үүсвэр талаас гадаад валютын харилцах мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарах гол шалтгаан боллоо. Тухайлбал, 2023 оны 3 дугаар сард гадаад валютын харилцах мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 8.8 нэгж хувийг бүрдүүлж байсан бол аж ахуй нэгжүүдийн валютын харилцах дансны өөрчлөлтөөс үүдэн 2023 оны 4 дүгээр сард мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд 1.6 нэгж хувийн нөлөөг үзүүлэв.

Харин 2023 оны 4 дүгээр сард мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 5.3 нэгж хувийг төгрөгийн харилцах, 0.6 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 3.6 нэгж хувийг гадаад валютын хадгаламж тус тус тайлбарлаж байна.

Зураг 3.9 Банкуудын зээл, хадгаламжийн долларжилт



Эх сурвалж: Монголбанк


Банкны системийн гадаад валютын эх үүсвэр буурч, төгрөгийн эх үүсвэр өссөнөөр эх үүсвэрийн долларжилт 2023 оны 4 дүгээр сард 31.5 хувьд хүрч, өмнөх сараас 4.7 нэгж хувиар буурав. Гэхдээ энэ нь өмнөх оны мөн үеэс 1.9 нэгж хувиар өндөр дүн юм. Гадаад валютын ханшийн нөлөөг хасаж тооцвол эх

¹³ Бизнес эрхлэх зориулалтаар иргэд болон аж ахуй нэгжид олгосон зээл юм. Зураг 3.12-т бизнесийн зээлийг боловсруулах, худалдаа, барилга, уул уурхай болон бусад салбар гэж ангилав.

үүсвэрийн долларжилт 26.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар, өмнөх сараас 4.0 нэгж хувиар тус тус буурлаа (Зураг 3.9).

Өмнөх оны сүүлийн улирлуудад хурдацтай саарч байсан банкны системийн зээл 2023 оны 4 дүгээр сард 4.2 хувиар өсөж, өсөлт оны эхнээс харьцангуй тогтвортой байна (Зураг 3.10).

Зураг 3.10 Арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн зориулалтаар нь ангилж харвал хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл жилийн 19.1 хувиар өссөн нь нийт зээлийн өсөлтийг голлон тэтгэж (5.0 нэгж хувь) байна. Харин бизнесийн¹³ болон ипотекийн зээл өмнөх жилийн мөн үеэс харгалзан 1 болон 1.7 нэгж хувиар хумигдаж, нийт зээлийг 0.6 болон 0.2 нэгж хувиар бууруулав. Бизнесийн зээл дотроо уул уурхайн салбарын зээлийн үлдэгдэл ихээр буурсан¹⁴ бол бусад ихэнх салбаруудын¹⁵ зээлийн үлдэгдэл өсөлттэй байна (Зураг 3.10).


Нийт зээлийг валютын төрлөөр нь авч үзвэл төгрөгийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн

¹⁴ Уул уурхайн салбарын зээл жилийн 27.3 хувиар буурсан нь нийт зээлийн өсөлтийг -2.1 нэгж хувиар бууруулав.

¹⁵ Худалдааны салбарын зээл нийт зээлийн өсөлтийн 1 нэгж хувийг, боловсруулах салбарын зээл 0.6 нэгж хувийг бүрдүүлж байна.

үеэс 4.3 хувиар, гадаад валютын зээлийн үлдэгдэл 3.1 хувиар нэмэгдэж зээлийн долларжилт нам түвшинд хэвээр байна (Зураг 3.11).

Зураг 3.11 Банкны системийн чанаргүй зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар




Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн зээлийн чанарт томоохон өөрчлөлт байхгүй байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл 2023 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 153 тэрбум төгрөгөөр өсөж 2.3 их наяд төгрөгт хүрсэн нь нийт зээлийн багцын 9.7 хувийг бүрдүүлж байна. Салбараар авч үзвэл, худалдаа болон барилгын салбарт илүү зээл чанаргүйдсэн байна (Зураг 3.11).

Харин банкны системийн анхаарал хандуулах зээл сүүлийн саруудад нэмэгдэж байна. Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл 2023 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 386 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 1.4 их наяд төгрөгт хүрснээр нийт зээлийн багцын 5.9 хувийг¹⁶ бүрдүүлэв. Эдийн засгийн бүх салбарт анхаарал хандуулах зээл өсөж байгаагийн дотор барилга, боловсруулах, уул уурхайн салбарын анхаарал хандуулах зээл илүү нэмэгдсэн байна (Зураг 3.12).

Зураг 3.12 Банкны системийн анхаарал хандуулах зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар




Эх сурвалж: Монголбанк

3.2.2. Хүү

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2023 оны 2 дугаар улирлын ээлжит хурлаар бодлогын хүүг 13 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. Банк хоорондын захын хүүнүүд бодлогын хүүний голч орчимд тогтвортой байна.

Зураг 3.13. БХЗ-ын хэлцлийн хүү



Эх сурвалж: Монголбанк


Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2023 оны 5 дугаар сард 12.96 хувь буюу өмнөх улирлын орчимд байв. Тодруулбал, ТБҮЦ барьцаалсан репо хэлцэл, ТБҮЦ-ны шууд хэлцэл, овернайт зээлийн хүү, банк хоорондын хадгаламжийн хүүнүүд харгалзан 13.00, 13.01, 12.84 хувь буюу

¹⁶ Энэ нь өмнөх жилийн мөн үеэс 1.5 нэгж хувиар өндөр байна.

өмнөх улирлын тайлангаас¹⁷ өөрчлөлт бага байна. (Зураг 3.13).

Энэ оны 5 дугаар сард шинээр олгосон төгрөгийн зээлийн дундаж хүү (хөнгөлөлттэй хүүтэй зээлүүдийг хасаж тооцвол) өмнөх тайлангаас 0.8 нэгж хувиар өссөн буюу 16.9 хувь байгаа бол банкуудын шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү 0.55 нэгж хувиар өсөж, 11.19 хувьд хүрлээ. Хөнгөлөлттэй хүүтэй зээлийг оруулж тооцвол нийт зээлийн хүү өмнөх улирлаас 0.4 нэгж хувиар өсөж 16.32 хувьтай байна. Ийнхүү хадгаламжийн хүү хурдтай өссөн нөлөөгөөр зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөхөөс 0.2 нэгж хувиар буурч, 5.1 хувьд хүрлээ (Зураг 3.14).

Зураг 3.14 Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү



Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү болон шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү нэмэгдлээ. Шинээр олгосон гадаад валютын зээлийн дундаж хүү 2023 оны 5 дугаар сард өмнөх улирлаас 0.74 нэгж хувиар өсөж 9.55 хувь болов. Шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү 0.36 нэгж хувиар өсөж 3.33 хувьд хүрлээ. Улмаар гадаад валютын

зээл, хадгаламжийн хүүний зөрүү 2023 оны 5 дугаар сард 0.4 нэгж хувиар өсөж, 6.2 хувь байна (Зураг 3.14).


Хүснэгт 3.1 Шинээр олгосон зээлийн хүү (₮)

Хувь, %	2022.5 сар	2023		
		1 сар	3 сар	5 сар
Зээлийн хүү (хөнгөлөлттэй зээлийг оруулснаар)	13.8	14.8	15.2	16.3
Зээлийн хүү	14.8	16.1	16.7	16.9
i. Улсын байгууллага	2.2	2.8	3.5	2.2
ii. Хувийн байгууллага	14.6	15.1	16.2	16.2
Үүнд: ААН-ийн ЖДҮ	14.9	16.1	17.6	15.3
iii. Санхүүгийн байгууллага	16.0	17.1	17.1	17.8
iv. Иргэд	15.2	17.0	17.3	17.5
Үүнд: Иргэдийн ЖДҮ	15.1	18.3	19.4	18.5
Хэрэглээ, хад.барь	16.3	16.0	18.7	18.3
v. Бусад байгууллага	12.7	-	16.8	16.9

3.2.3 Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сүүлийн 4 улирал дараалан суларч 3521.9 төгрөгт хүрч байсан бол 2022 оны 11 дүгээр сараас ханшийн сулрах хурд саарч, улмаар 2023 оны 3 дугаар сараас эхлэн ханш чангарч эхлэсэн бөгөөд 2023 оны 5 дугаар сарын байдлаар 3475.7 төгрөг болоод байна (Зураг 3.15).

Зураг 3.15 Төгрөгийн ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Монголбанк


Үүнд, экспортын орох урсгал нэмэгдэж, гадаад валютын урсгал цэвэр дүнгээр 2023

¹⁷ Өмнөх инфляцын тайланд 2023 оны 1 дүгээр сарын үзүүлэлтийг танилцуулсан ба цаашид 2023 оны 1 дүгээр сарын хүүгийн түвшинтэй харьцуулна.

оны эхний 5 сарын турш эерэг байсан нь нөлөөлөв. Гэвч АНУ-ын Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ 2023 оны 5 сард үргэлжлүүлэн нэмэгдүүлж, ам.долларын ханш бусад валютуудын эсрэг чангарч байгаа нь төгрөгийн ханшид сулрах дарамт үзүүлсэн хэвээр байна.

Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) энэ оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар сул тогтлоо. Үүнээс төгрөгийн ханш өмнөх оны мөн үеэс ам.долларын эсрэг 12.7 хувиар, юанийн эсрэг 7.2 хувиар, еврогын эсрэг 17.5 хувиар тус тус суларсан байна. Харин рублийн эсрэг 0.5 хувиар чангарав (Зураг 3.16).


Зураг 3.16 Төгрөгийн гол валютуудтай харьцах ханш, нэрлэсэн үйлчилж буй ханшийн (NEER) жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн нэрлэсэн ханш өмнөх оны мөн үеэс суларч, гадаад үнэтэй харьцуулахад дотоод үнэ буурснаар бодит үйлчилж буй ханш энэ оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар суларсан хэвээр байна (Зураг 3.17).


Зураг 3.17 Төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн ханш ам.долларын эсрэг суларсантай холбоотойгоор төгрөгийн харьцангуй өгөөж 2022 оны 3 сараас хойш сөрөг түвшинд хадгалагдаж байсан бол 2023 оны 4 дүгээр сарын байдлаар нэмэгдэн 1.5 хувьд хүрээд байна (Зураг 3.18). Төгрөгийн харьцангуй өгөөж эерэг түвшинд хүрснээр төгрөгийн хадгаламж буурах, валютын хадгаламж өсөх нөлөө буурлаа.

Зураг 3.18 Төгрөгийн харьцангуй өгөөж



Эх сурвалж: Монголбанк

3.2.4. Хөрөнгийн зах зээл


Тайлант улиралд хөрөнгийн зах зээлийн идэвхжил үргэлжлэн сайжирч орон сууцны зах зээл дээр үнэ харьцангуй тогтвортой байв.

Орон сууцны зах зээл

Тайлант улиралд орон сууцны болон түрээсийн үнэ бага зэрэг буурлаа (Зураг 3.19). Орон сууцны нийт үнийн индекс жилийн 0.4 хувиар, үүнд шинэ болон хуучин орон сууцны үнэ тус бүр 0.2 хувиар


буурав. Улирлын өөрчлөлтийн хувьд мөн нийт орон сууцны үнэ төдийлөн өөрчлөлтгүй буюу өмнөх улирлаас 0.4 хувиар өсжээ (Зураг 3.19).

Зураг 3.19 Орон сууцны үнэ ба түрээсийн үнийн жилийн өсөлт



Орон сууцны түрээсийн үнэ¹⁸ жилийн 1.0 хувиар буурсан бол улирлын 0.8 хувиар өсөв. Ингэснээр, орон сууц болон түрээсийн үнийн өсөлтийн зөрүү сүүлийн нэг жил гаруй хугацаанд харьцангуй тогтвортой буюу +/-3 хувийн хооронд хэлбэлзэж байна (Зураг 3.20).

Зураг 3.20 Орон сууцны үнэ ба түрээсийн үнийн улирлын өсөлт



¹⁸ Өмнөх инфляцын тайлангуудад YCX-ны ХҮИ-ийн сагсанд багтдаг Түрээсийн байрны индексийг ашигладаг байсан бол энэ удаагийн тайланд "Тэнхлэг зууч" ХХК-ийн тооцдог Орон сууцны түрээсийн үнийн индексийг ашигласан болно.

Орон сууцны үнэ 2021 онд эрчимтэй өссөн суурь үеийн нөлөөнөөс гадна ипотекийн зээлийн өсөлт саарч, өрхийн бодит орлого бууран, өрхийн орон сууц худалдан авах чадвар төдийлөн нэмэгдэхгүй байгаа нь сүүлийн саруудад орон сууцны үнэ харьцангуй тогтвортой байхад нөлөөлж байна. Тухайлбал, өрхийн сарын дундаж орлого нэрлэсэн дүнгээр тайлант улиралд жилийн 5.7 хувиар өссөн¹⁹ боловч өрхийн бодит орлого²⁰ жилийн 3.9 хувиар буурав.

Өрхийн нэрлэсэн орлого, орон сууцны үнээс илүү өссөн хэвээр байгаа тул үнэ-орлогын харьцаа тайлант улиралд үргэлжлэн буурлаа (Зураг 3.21).

Зураг 3.21 Үнэ-орлого ба үнэ-түрээсийн харьцаа




Барилгын өртгийн индекс 2023 оны эхний улиралд жилийн 33.6 хувь, улирлын 6.0 хувиар өсөв (Зураг 3.22). Төгрөгийн ханш суларч, импортын бараа, материалын үнэ нэмэгдэж буй нь барилгын өртөг үргэлжлэн өсөхөд нөлөөлж байна. Тодруулбал, өсөлтийн дийлэнх хэсгийг буюу 22.9 нэгж хувийг материалын өртөг бүрдүүлсэн бол цалингийн зардал болон машин механизмын түрээсийн зардал харгалзан 8.8

¹⁹ Өрхийн цалингийн орлого жилийн 27.7 хувиар өссөн боловч бусад орлогууд 11.6 хувиар буурснаас шалтгаалан өрхийн сарын дундаж орлого 5.7 хувиар өсөв. Эх сурвалж: YCX

²⁰ ХҮИ-р засварлав.

болон 1.9 нэгж хувийн нөлөөг тус тус үзүүлэв.

Зураг 3.22 Орон сууцны барилгын өртгийн индекс (БӨИ)




Эх сурвалж: YCX

Хөрөнгийн зах зээл

Хөрөнгийн зах зээл тайлант улиралд үргэлжлэн идэвхжив. Тодруулбал, ТОП 20 индекс 2022 оны 10 сараас эхлэн 6 сарын турш тасралтгүй нэмэгдэж 2023 оны эхний улиралд өмнөх улирлаас 9.5 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад мөн 5.5 хувиар буурав. Харин зах зээлийн үнэлгээ тайлант улиралд өмнөх улирлын дунджаас 14.7 хувиар, өмнөх жилийн мөн үеэс 22.3 хувиар өслөө (Зураг 3.23).


Зураг 3.23 Хөрөнгийн захын голлох үзүүлэлтүүд



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Үнэт цаасны арилжааны дүн 2023 оны эхний улиралд 74.1 тэрбум төгрөг байсан нь өнгөрсөн оны мөн үеэс 38 хувиар, өмнөх улирлаас 3.4 дахин бага үзүүлэлт юм (Зураг 3.24). Өмнөх улирлаас ингэж огцом буурахад системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат компани болох хуулийн хүрээнд “Голомт банк” 118.8 тэрбум төгрөгийн хувьцааг 2022 оны 12 дугаар сард анхдагч зах зээл дээр гаргасантай холбоотой байна. Нийт арилжааны бүтцийг авч үзвэл 70.9 хувийг хувьцааны арилжаа бүрдүүлсэн бөгөөд үүний 54.8 хувь нь хоёрдогч зах зээлийн арилжаа байлаа. Харин 16 хувийг компанийн бондын арилжаа, 9.8 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа (ХБҮЦ) бүрдүүлэв.

Зураг 3.24 Нийт арилжаа, бүтцээр²¹



Эх сурвалж: YCX, Монголбанк

Тайлант хугацаанд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 135.57 сая ширхэг буюу 40.62 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хувьцаа арилжигджээ. Үүнээс хамгийн идэвхтэй буюу их дүнгээр арилжаалагдсан компаниуд бол Голомт банк (8.16 тэрбум), Монголын хөрөнгийн бирж (4.12 тэрбум) болон Атар өргөө (4.0 тэрбум) ХК-иуд юм. Нийт 127 ХК-ийн үнэт цаас арилжигдсанаас 59 компанийн үнэт цаасны ханш өсч, 63 компанийн үнэт

²¹ Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ), Хөрөнгө оруулалтын сан (ХОС)

цаасны ханш буурч, 5 компанийн үнэт цаасны ханш тогтмол арилжигдсан байна.

Хувьцааны анхдагч арилжааны хувьд зөвхөн “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн нийтэд санал болгосон 11.92 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд энэ нь нийт хувьцааны арилжааны 23 хувийг эзэлж байна.

Компанийн бондын арилжааны хувьд анхдагч зах зээлд зөвхөн “Сэндли ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан 8.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 85 мянган ширхэг өрийн хэрэгсэл арилжигдсан бол хоёрдогч зах зээлд 3.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 33.65 мянган ширхэг өрийн хэрэгсэл арилжигджээ.

ХБҮЦ-ны арилжаа өнгөрсөн онд идэвхжиж 98.9 тэрбум төгрөгт хүрээд байсан бол тайлант улиралд 7.3 тэрбум төгрөг хүрч буурсан. Харин Хөрөнгө оруулалтын сан (ХОС)-гийн арилжаа өнгөрсөн оны турш нам түвшинд байсан бол энэ оны эхний улиралд 2.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх улирлаас 2.4 дахин өсчээ.

3.3. Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр

Нэгдсэн төсөв: Эхний 5 сарын байдлаар төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 43.2 хувиар өндөр төвлөрч, 8.5 их наяд төгрөгт хүрсэн бол зардал 9.7 хувиар их буюу 7.1 их наяд төгрөг байв. Ийнхүү тэнцвэржүүлсэн тэнцэл 1.4 их наяд төгрөгийн ашигтай гарлаа (Хүснэгт 3.2).

Тэнцвэржүүлсэн орлого 2023 онд: Төсвийн орлого өмнөх оноос эрчтэй нэмэгдэж буйд эдийн засгийн идэвхжил, экспорт өссөн зэрэг нь голлон нөлөөлж байна. Тухайлбал, оны эхний 5 сард ААНОАТ болон АМНАТ-ын орлого


бүрдүүлэлт өндөр байж, татварын орлого өмнөх оноос 44.0 хувиар, газрын тосны экспорт хэвийн үргэлжилж орлого нь сэргэснээр татварын бус орлого 29.4 хувиар тус тус өсөв (Зураг 3.25).

Хүснэгт 3.2 Төсвийн үндсэн үзүүлэлтүүд

Их наяд төгрөг	2022	2023	2023.05	
	Гүй.	Бат.	Гүй.	Гүй%
Нийт орлого	18.6	19.7	9.0	105.1
Сангийн орлого	1.4	0.7	0.5	4.5х
Тэнцвэржүүлсэн орлого	17.2	19.0	8.5	101.0
Татварын орлого	15.6	17.2	8.1	103.4
Татварын бус орлого	1.6	1.9	0.4	69.7
Нийт зардал	18.2	20.5	7.1	82.6
Анхдагч зардал	17.4	19.3	6.6	82.0
Хүүний зардал	0.8	1.2	0.5	92.1
Нийт тэнцэл	0.4	-0.8	1.8	
ДНБ-д эзлэх хувь	0.9%	-1.4%	3.4%	
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1.0	-1.4	1.4	
ДНБ-д эзлэх хувь	-2.1%	-2.6%	2.6%	
Анхдагч тэнцэл	-0.2	-0.2	1.9	
ДНБ-д эзлэх хувь	-0.3%	-0.4%	3.5%	

Эх сурвалж: Сангийн яам

Зураг 3.25 Төсвийн орлогын бүтэц, оны эхний 5 сард




Эх сурвалж: Сангийн яам

Нийт зардал, цэвэр зээл 2023 онд: Засгийн газар энэ онд “Хуримтлалтай хүүхэд”, чанар, гүйцэтгэл, хүрэх үр дүнд чиглэсэн төсвийн санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Иймээс татаас, шилжүүлгийн зардал өмнөх оны адил нийт зардлын тал орчим хувийг бүрдүүллээ²².

²² 2010-2020 оны дундаж 32 хувь, 2021 онд 47 хувь, 2022 онд 53 хувь, 2023 оны эхний 5 сард 57 хувь

Зураг 3.26 Төсвийн зардлын бүтэц, оны эхний 5 сард



Эх сурвалж: Сангийн яам

Эхний 5 сарын байдлаар татаас, шилжүүлгийн зардал өмнөх оны мөн үетэй адил түвшинд байсан бол гадаад зээлийн хүүний төлбөр, бараа үйлчилгээний зардал нэмэгджээ. Тухайлбал, Сангийн яамны төлөвлөснөөр 2023 оны зээлийн хүүний зардал өмнөх оноос 45 хувиар өндөр бөгөөд эхний 5 сарын төлөвлөсөн зарцуулалт нь 92 хувийн гүйцэтгэлтэй байна (Зураг 3.26).

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр: Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өрийн нэрлэсэн ДНБ-д эзлэх хувь 2023 онд 65.0 хувь байхаар батлагдсан нь хуульд²³ заасан хязгаарыг хангаж байна (Хүснэгт 3.3). Төсвийн тодотголоор үүнд өөрчлөлт ороогүй.

Хүснэгт 3.3 Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өр болон зээлийн үйлчилгээний төлбөр

	2021	2022	2023*	2023*
тэрбум төгрөг	Гүй.	Гүй.	Бат.	Тод.
Засгийн газрын нийт өр (ӨҮЦ)	21837	27679	35435	39126
ДНБ-д эзлэх хувь	50.1	52.4	65.0	65.0
Өрийн хязгаар	70.0	70.0	65.0	65.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	828	816	1181	1181
Төсвийн орлогод эзлэх хувь	6.5	4.7	6.2	6.2
Төсвийн тэнцэл	-2909	-979	-1426	-1590
ДНБ-д эзлэх хувь	-4.5	-1.9	-2.6	-2.6

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

²³ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2023 онд 65, 2024 онд 60 хувиас хэтрүүлэхгүй байхаар заажээ.

Шигтгээ. 2023 оны Төсвийн тодотгол

Энэ удаагийн төсвийн тодотголоор батлагдсан төсвөөс төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 1.7 их наяд, төсвийн зардлыг 1.9 их наядаар нэмэгдүүлж тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 1.6 их наяд төгрөг байхаар боловсруулсан байна (Хүснэгт 3.4).

Хүснэгт 3.4 Төсвийн үндсэн үзүүлэлт

Их наяд төгрөг	2023			
	Бат.	Тод.*	Δ	Δ %
Нийт орлого	19.7	21.8	2.1	10.7%
Сангийн орлого	0.7	1.0	0.4	54.8%
Тэнцвэржүүлсэн орлого	19.0	20.8	1.7	9.1%
Татварын орлого	17.2	18.9	1.7	10.0%
Татварын бус орлого	1.9	1.9	0.0	0.4%
Нийт зардал	20.5	22.4	1.9	9.3%
Анхдагч зардал	19.3	21.3	2.0	10.3%
Хүүний зардал	1.2	1.1	-0.1	-7.4%
Нийт тэнцэл	-0.8	-0.5		
ДНБ-д эзлэх хувь	-1.4%	-0.9%		
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1.4	-1.6		
ДНБ-д эзлэх хувь	-2.6%	-2.6%		
Анхдагч тэнцэл	-0.2	-0.5		
ДНБ-д эзлэх хувь	-0.4%	-0.8%		

Эх сурвалж: Сангийн яам

Гадаад сорилт, тодорхой бус байдал өндөр байгаа хэдий ч экспортын тээвэрлэлтэд үүсээд байсан хүндрэл арилсан нь манай экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний экспортод эерэгээр нөлөөлж байна. Тухайлбал, хилийн боомтууд дээр хийгдэж буй өргөтгөл, шинэчлэлтийн ажлуудын үр дүнд оны эхний 4 сарын байдлаар 19 сая тонн нүүрс экспортолсон нь өмнөх жилүүдэд гарч байгаагүй өндөр үзүүлэлт юм. Гэхдээ төсвийн орлогын цаашдын төлөв экспортын хэмжээнээс ихээхэн хамаарахаар байна.

Төсвийн тодотголоор дараах чиглэлд урсгал зардлыг нэмж төсөвлөсөн байна. Үүнд: 1) төрийн албаны цалингийн тогтолцоонд шинэчлэл хийж хэт олон шатлалыг өөрчлөх, цалингийн доод хэмжээг нэмэгдүүлэх зэргээр төрийн албан хаагчдын цалин нэмэгдүүлэхэд **986.6** тэрбум төгрөг, 2) ахмад настны тэтгэврийн зөрүүг ойртуулж, тэтгэврийн хэмжээг өсгөхөд **394.6** тэрбум төгрөг, 3) хүүхдийн тэтгэмжийг хүсэлт

гаргасан бүх хүүхдэд олгохоор болсон нь **167.2** тэрбум төгрөг 4) нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэн нь **89.8** тэрбум төгрөгийн нэмэлт зардал шаардахаар байна. Түүнчлэн нийслэлийн түгжрэлийг бууруулах ажилд нэмэлт 187.0 тэрбум төгрөгийг төсөвлөжээ. Ингэснээр энэ оны төсвийн зардал 2022 оны гүйцэтгэлээс **23.2** хувиар, 2023 оны батлагдсан төсвөөс **9.3** хувиар өсөж **22.4** их наядад хүрэхээр байна.

4. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН


4.1 Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл

Гадаад эрэлт: Дэлхийн эдийн засгийн 2023 оны өсөлтийн төсөөлөл өмнөх төсөөллөөс нэмэгдэв. Үүнд 1) БНХАУ-ын цар тахалтай тэмцэж буй бодлогын арга хэмжээ суларснаар тус улсын үйлчилгээний салбарын өсөлт 2023 оны I улиралд хүлээлтээс хурдтай сэргэсэн, 2) нийлүүлэлтийн сүлжээний доголдол харьцангуй сайжирч, тээврийн зардал буурч байгаа нь голлон нөлөөлсөн байна. Гэхдээ ОХУ-Украины нөхцөл байдалтай холбоотой тодорхой бус байдал болон АНУ, Европын холбоо зэрэг томоохон эдийн засагтай улсуудын банк, санхүүгийн зах зээлд үүсээд буй хүндрэл цаашид даамжрах эрсдэл нь өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

БНХАУ-ын эдийн засаг I улиралд 4.5 хувиар өссөн нь шинжээчдийн төсөөллөөс 0.6 нэгж хувиар өндөр үзүүлэлт боллоо. Үүнд үйлчилгээний салбарын идэвхжил, тэр дундаа аялал жуулчлалын салбарын эрчтэй сэргэлт голчлон нөлөөлж байна. Гэхдээ тус улсын аж үйлдвэрийн салбарын сэргэлт хүлээлтээс удаан байна. Тодруулбал аж үйлдвэрийн PMI индекс “Тэг-Ковид” бодлогын арга хэмжээ суларсны дараа оны 2-р сард 51.7-д хүрч нэмэгдээд байсан бол сүүлийн саруудад огцом буурч 4-р сард 49.5

нэгж болжээ. Шинжээчдийн дүгнэлтээр тус улсын худалдааны гол түнш орнуудын эдийн засгийн идэвхжил сул хэвээр байгаагийн зэрэгцээ банк, санхүүгийн салбарын эрсдэл нэмэгдсэн нь БНХАУ-ын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний эрэлтэд сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн аж үйлдвэрийн салбар цаашид бүрэн сэргэхэд хугацаа шаардлагатай байгааг ОУВС-гийн шинжээчид анхааруулжээ. Хэдийгээр аж үйлдвэрийн салбарын сэргэлт ийнхүү хүлээлтээс удаан байгаа ч үйлчилгээний салбарын эрчтэй сэргэлт энэ онд эдийн засгийн өсөлтийг тэтгэх төлөвтэй.

Зураг 4.1 Улс орнуудын өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Блүмберг, Рубини, EIU, ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын төсөөллийн

АНУ-ын эдийн засгийн өсөлт 2023 оны I улиралд 1.6 хувьд хүрч, төсөөллөөс 1.3 нэгж хувиар өндөр байв. Эдийн засгийн өсөлт ийнхүү хүлээлтээс өндөр гарсан ч эдийн засгийн өсөлт 2023 оны туршид саарах төлөвтэй байна. ОУВС-гийн шинэчилсэн төсөөллөөр АНУ-ын мөнгөний хатуу бодлогын нөлөө эдийн засагт энэ онд хүчтэй илрэх, банкны системд зээлийн тасалдал үүсэх эрсдэл нэмэгдсэн нь өсөлтийн төсөөлөл бага түвшинд хэвээр хадгалагдах гол үндэслэл болж байна. Банкны системд активийн хэмжээгээр 14, 16, 29-т

эрэмблэгдэх 3 банк (First Republic, Silicon Valley, Signature) дампуурлаа зарласан бөгөөд банкны систем дэх хүндрэлээс үүдэн банкуудын зээлийн нөхцөл чангарах, улмаар эдийн засагт зээлийн тасалдал үүсэх эрсдэл нэмэгджээ.

Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2023 оны I улиралд 0.1 хувьд хүрч хүлээлтээс²⁴ бага байв. Европын төв банк бодлогын хүүгээ эрчтэй өсгөсөн шийдвэрүүдийн нөлөө энэ онд Европын холбооны эдийн засгийн өсөлт, санхүүгийн зах зээлд хүчтэй илрэх төлөвтэй талаар ОУВС-гийн шинэчилсэн төсөөлөлд тайлбарлажээ.

ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2023 оны I улиралд -1.9 хувьд хүрч хүлээлтээс сайн гарав. ОХУ-ын эдийн засаг Европын холбооны хэрэгжүүлж буй газрын тос, бусад түүхий эдүүдийн худалдааны хоригийн улмаас саарч байгаа хэдий ч БНХАУ, Энэтхэг тэргүүтэй улсууд руу экспортын хэмжээ нэмэгдсэн нь тус улсын эдийн засгийн өсөлтийг хүлээлтээс сайжруулж байна.

Гадаад инфляц: Дэлхийн ихэнх оронд инфляцын эрч саарч байна. Тухайлбал, АНУ-д инфляц 2022 оны 6 дугаар сард 9.1 хувь буюу сүүлийн 40 жилийн оргил түвшинд хүрээд байсан бол 2022 оны сүүлийн хагасаас эхлэн аажмаар саарч 2023 оны 4 дүгээр сард 4.9 хувьд хүрлээ. Европын холбооны орнуудын инфляц 4 дүгээр сард 7.0 хувьд хүрч өмнөх оны 10 дугаар сараас 3.6 нэгж хувиар буурлаа. Үүнд голчлон эрчим хүчний үнэ сүүлийн саруудад буурсан нь нөлөөлжээ. Харин Англи улсын хувьд инфляцын түвшин өндөр түвшинд хадгалагдсан хэвээр байгаа бөгөөд 2023 оны 4 дүгээр сарын байдлаар 8.7 хувьтай байна. Олон улсын

шинжээчдийн төсөөллөөр глобал инфляц 2024 оны сүүлийн хагаст төв банкуудын зорилтот түвшний орчимд тогтворжих төлөвтэй байна.

Гадаад хүү: ХНБ 5 дугаар сарын хурлаар бодлогын хүүг 0.25 нэгж хувиар нэмэгдүүлж, 5.25 хувьд хүргэсэн бол цаашид бодлогын хүүг дахин нэмэгдүүлэх эсэх шийдвэр нь инфляцын гүйцэтгэл, банк, санхүүгийн системийн нөхцөл байдлаас голлон хамаарахаар байна. ХНБ-ы төсөөллөөр инфляц 2024 оны сүүлийн хагасаас зорилтот 2 хувийн түвшинд хүрч тогтворжих төлөвтэй.

Хэдийгээр Евро бүсэд инфляц саарч байгаа ч өндөр түвшинд хэвээр байгаа тул Европын төв банкнаас бодлогын хүүг 3-р сарын хурлаар 0.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 3.5 хувьд хүргэв. Европын холбоо бодлогын хүүгээ 5, 6, 7 саруудын хурлаар үргэлжлүүлэн нэмэгдүүлэх хүлээлттэй байна.

4.2. Экспортын үнийн төлөв

БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт, төв банкуудын мөнгөний бодлого, ОХУ-Украины нөхцөл байдлаас голлон хамаарахаар байна.

Зэс: Зэсийн үнэ 2023 оны 4 дүгээр сарын эцэст 8595 ам.доллар/тн хүрч оны эхнээс 6.8 хувиар буурлаа. БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын сэргэлт хүлээлтээс удаан байгаатай холбоотойгоор зэсийн эрэлт, үнэ буураад байна. БНХАУ-ын барилгын салбар дахь Засгийн газрын хөрөнгө оруулалт энэ оны сүүлийн хагаст нэмэгдэхээр байгаа нь барилгын салбарын идэвхжилийг тэтгэснээр зэсийн эрэлт нэмэгдэх төлөвтэй байна.

Алт: Алтны үнийн төсөөлөл 2023 онд унц тутамдаа 1788 ам.доллар болж өмнөх

²⁴ Шинжээчдийн өмнөх төсөөллөөр Евро бүсийн эдийн засгийн өсөлтийг 2022 онд 3.1 хувьд хүрэх төсөөлөлтэй байв.

төсөөллөөс 136 ам.доллараар өсөв. Цаашид ОХУ-Украины нөхцөл байдлын улмаас глобал орчинд тодорхой бус байдал зонхилох төлөвтэй байгаа тул алтны үнийн төсөөлөл нэмэгдлээ.

Коксжих нүүрс: БНХАУ-ын дотоодын коксжих нүүрсний үйлдвэрлэл болон импортын нүүрсний биет хэмжээ эрчтэй нэмэгдсэнээр дотоодын нүүрсний нөөц сүүлийн 3 жилийн хамгийн өндөр түвшинд хүрэв. Үүнээс шалтгаалан БНХАУ-ын дотоодын зах зээлд нүүрсний үнэ буурч байна. Мөн дотоодын нүүрс шатаах үйлдвэрүүдийн эрэлт бага байгаа нь үнэ буурахад давхар нөлөөлж байна. Ганцмод боомтоор экспортлогдож буй коксжих нүүрсний үнэ 5-р сарын 17-ны байдлаар оны эхнээс 21 хувиар буурлаа²⁵.

Төмрийн хүдэр: Төмрийн хүдрийн үнэ 4-р сарын эцэст тонн тутамдаа 107 ам.доллар болж оны эхнээс 10 орчим хувиар буурчээ. Төмрийн хүдрийн томоохон хэрэглэгч БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт хүлээлтээс удаан байгаатай холбоотойгоор төмрийн хүдрийн үнэ саарч байна. Цаашид БНХАУ-ын барилгын салбарын идэвхжил сэргэх хүлээлтээс шалтгаалан төмрийн хүдрийн үнийн төсөөлөл нэмэгдлээ.

Газрын тос: Брент газрын тосны үнэ 4-р сарын эцэст 79.5 ам.доллар/баррель болж өмнөх улирлаас 5 хувиар буурчээ. ОПЕК-ын орнууд 4-р сарын эхээр үйлдвэрлэлээ өдөрт 1.16 сая баррелиар²⁶ бууруулах шийдвэр гаргасны дараа үнэ 85 ам доллар болж нэмэгдээд байсан бол БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт хүлээлтээс удаашралтай байгаатай холбогдон үнэ эргэн буурч байна.

Худалдааны нөхцөл:

Худалдааны нөхцөлийн жилийн өөрчлөлт өмнөх төсөөллийн орчимд хэвээр байна (Зураг 4.2). Зэс, алтны үнийн төсөөлөл өмнөх төсөөллөөс нэмэгдсэн ч газрын тосны үнийн төсөөлөл буурснаар экспортын үнийн төсөөлөл төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

Зураг 4.2 Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

4.3. Төлбөрийн тэнцэл

Монгол Улсын төлбөрийн тэнцэл урьдчилсан гүйцэтгэлээр 2023 оны I улиралд 80 сая ам.долларын ашигтай гарлаа²⁷.

- Нүүрсний экспортын биет хэмжээ 2023 оны I улиралд түүхэн дээд түвшинд хүрч нэмэгдсэн нь экспортын орлогыг тэтгэж, урсгал тэнцлийн алдагдлыг бууруулав.
- Өрхийн хэрэглээ тайлант улиралд агшсан нь хэрэглээний бүтээгдэхүүний импорт буурахад нөлөөллөө.
- Гэхдээ хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортын өсөлт, үйлчилгээний дансны алдагдал өндөр хэвээр хадгалагдаж байна.

Гадаад валютын албан нөөц 2023 оны I улирлын эцэст 3.4 тэрбум ам.доллар буюу


²⁵ SXCoal вэбсайтны мэдээлэл

²⁶ Дэлхий даяар өдөрт 90 орчим сая баррель газрын тос үйлдвэрлэж, 100 орчим сая газрын тос хэрэглэдэг.

²⁷ Төлбөрийн тэнцлийн дэлгэрэнгүй статистикийг stat.mongolbank.mn хаягт хандан авах боломжтой.

оны эхэн үеийн түвшинд хэвээр байна. Гадаад эдийн засгийн орчны тодорхой бус байдал өндөр хэвээр, гэнэтийн сөрөг өөрчлөлтүүд илрэх магадлал их байгаа өнөөгийн нөхцөлд гадаад секторын эрсдэл даах чадварыг үргэлжлүүлэн сайжруулах шаардлагатай юм. Энэ нь эдийн засгийн гадаад болон дотоод тэнцвэрийг хангахад чухал ач холбогдолтой.

Зураг 4.3 Төлбөрийн тэнцэл 2023 оны эхний улиралд 80 сая ам.долларын ашигттай байв.



Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн тэнцлийг гол бүрэлдэхүүн хэсгүүдээр дэлгэрүүлж тайлбарлавал:

Экспортын орлого 2023 оны I улиралд өмнөх оны мөн үеэс 96.0 хувиар өсжээ. Чулуун нүүрсний 1 улиралд гаргасан экспортын биет хэмжээ түүхэн дээд түвшинд хүрч сайжирсан нь тайлант улирлын экспортын орлогын өсөлтийн 81.7 нэгж хувийг дангаар бүрдүүлэв. Түүнчлэн, өмнөх оны мөн үед экспортод гараагүй мах, махан бүтээгдэхүүн, боловсруулаагүй нефть, хуш модны самрын экспорт энэ онд хэвийн гарч байгаа тул эдгээр 3 бүтээгдэхүүний экспортын орлого нийт экспортын орлогод 13.1 нэгж хувийн өсөлтийг бий болгосон байна.

Оны эхний улиралд зэсийн баяжмалын орлого буурсан нь баяжмал дахь алтны агууламж багассанаас гадна зэсийн үнэ өмнөх оны мөн үеэс 10 орчим хувиар

доогуур байсантай холбоотой юм. Харин мөнгөжөөгүй алтны хувьд экспортын биет хэмжээ 50 орчим хувиар бага байв (Хүснэгт 4.1).

Хүснэгт 4.1 Нүүрсний экспорт нийт экспортын өсөлтийг голлон бүрдүүлж байна.

сая ам.доллар	2022 I	2023 I	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт экспорт	1,921	3,764	96.0	96.0
Чулуун нүүрс	676	2,244	232.2	81.7
Мах, махан бүтээгдэхүүн	0	99		5.2
Боловсруулаагүй нефть	-	88		4.6
Бусад самар	2	65		3.3
Цайрын хүдэр, баяжмал	41	98	138.1	3.0
Төмрийн хүдэр, баяжмал	57	109	90.5	2.7
Жонш, лейцит, нефелин	12	44	282.7	1.7
Молебдиний хүдэр, баяжмал	15	38	151.8	1.2
Мөнгөний хүдэр, баяжмал	7	28	302.2	1.1
Зэсийн хүдэр, баяжмал	711	632	-11.2	-4.1
Мөнгөжөөгүй алт	288	156	-45.8	-6.9
Бусад	112	162	44.6	2.6

Эх сурвалж: ГЕГ

Импорт энэ оны I улиралд өмнөх оны мөн үеэс 14.7 хувиар нэмэгдэв. Энэхүү өсөлтийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт болон дизель түлшний импорт тайлбарлаж байна. Нүүрсний экспортын тээвэр саадгүй үргэлжилж, их хэмжээний нүүрс экспортолсон нь дизель түлшний хэрэглээг нэмэгдүүлж, цаашлаад хөрөнгө оруулалтын шинжтэй барааны эрэлтийг ч нэмэгдүүлж байна.

Өмнөх 2 жилд жилийн өсөлт нь дунджаар 30 хувийг даваад байсан хэрэглээний бүтээгдэхүүний импорт 1-р улиралд жилийн 6 хувиар агшив. Үүнд, суудлын автомашинаас бусад хэрэглээний импорт буурсан нь нөлөөлөв (Хүснэгт 4.2).


Хүснэгт 4.2 Импорт эхний улиралд 14.7 хувиар өсөв.

сая ам.доллар	2022 I	2023 I	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт импорт	1,691	1,940	14.7	14.7
Хэрэглээний бүтээгдэхүүн	609	573	-6.0	-2.2
Түргэн эдэлгээт	346	296	-14.6	-3.0
Удаан эдэлгээт	263	277	5.4	0.8
Суудлын автомашин	144	165	14.4	1.2
Хөрөнгө оруулалтын бүт.н	542	752	38.7	12.4
Нефтийн бүтээгдэхүүн	330	423	28.1	5.5
Дизель	151	261	72.7	6.5
Бусад шатахуун	179	162	-9.5	-1.0
Аж үйлдвэрлэлийн орц	204	189	-7.2	-0.9
Бусад	0.0	0.0	-50.6	0.0

Эх сурвалж: ГЕГ, Монголбанк


Үйлчилгээний дансны алдагдал тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 394 сая ам.доллараар тэлж 859 сая ам.долларт хүрлээ (Зураг 4.4). Нүүрсний экспортын биет хэмжээний өсөлттэй холбоотой экспортын тээврийн зардал, хилийн хөл хорио суларсантай зэрэгцэн хувийн аялал жуучлал болон эмчилгээний зардал өссөн нь үйлчилгээний дансны алдагдлыг нэмэгдүүлэх гол хүчин зүйлс боллоо.

Зураг 4.4 Үйлчилгээний дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 30 хувиар тэлэв.



Орлогын дансны алдагдал I улиралд 492 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 225 сая ам.доллараар нэмэгдлээ (Зураг 4.5). Үүнд дотоодын аж ахуйн нэгжүүдийн ногдол ашгийн орлогын гарах урсгал өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн нь нөлөөлжээ.


Зураг 4.5 Орлогын дансны алдагдал буурлаа.



Санхүүгийн дансны тэнцэл 2023 оны I улиралд 324 сая ам.долларын алдагдалтай

байв. Үүнд, тайлант хугацаанд хувийн секторын гадаад банкны дансанд байршсан харилцах, хадгаламжийн хэмжээ нэмэгдсэн, мөн импортын худалдааны зээл гарах урсгалтай байсан нь гол нөлөөллөө.

Зураг 4.6 Санхүүгийн данс алдагдалтай гарлаа.



Эх сурвалж: Монголбанк

Нөгөө талаас 2023 оны эхний улиралд багцын хөрөнгө оруулалт 222 сая ам.долларын орох урсгалтай байв. Тухайлбал, Засгийн газар өрийн дахин санхүүжилтийн хүрээнд “Центури – 2” 650 сая ам.долларын бондыг энэ оны 1-р сард гадаад зах зээлд гаргасан. Үүнээс, эхний улиралд 2024 онд эргэн төлөх хуваарьтай “Хуралдай” бондын 200 орчим сая ам.доллар, 2023 онд эргэн төлөх “Гэрэгэ” бондын 150 орчим сая ам.долларын үндсэн төлбөрийг дахин санхүүжүүлээд байна. Үлдсэн 300 орчим сая ам.долларыг 5-р сард “Гэрэгэ” бондын үлдэгдэл төлбөрийг дахин санхүүжүүлэхэд зарцууллаа.

ҮСХ-ны тооцоогоор **гадаад худалдааны нөхцөл** 2023 оны 3-р сард өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар муудлаа. Импортын үнийн индекс 3.8 хувиар буурсан боловч экспортын үнийн индекс 10.6 хувиар буурсан тул гадаад худалдааны нөхцлийн индекс ийнхүү муудаад байна. Импортын үнийн индекс буурахад нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ 9.2 хувиар хямдарсан нь голлон нөлөөлжээ. Харин экспортын үнэ буурахад зэсийн үнэ 9.5 хувиар, газрын тосны үнэ 17.3 хувиар хувиар тус тус буурсан нь нөлөөлөв.



МОНГОЛБАНК